

**ХЯТАД ХЭЛНИЙ ХЭЛЦ ҮГИЙН БҮТЭЦ, ОНЦЛОГ,
ТҮҮНИЙ ЗААХ АРГЫН АСУУДАЛД**

Л. Солонго *

摘 要: 每个民族智慧、语言及文化的结晶——成语，是传递着丰富多彩的文化内涵、包含着独特的民族特征。怎么教汉语成语是蒙古国汉语教学的难点，也是教学中值得关注的环节之一。分析对外汉语教学中的成语问题的意义在于使蒙古留学生正确把握并运用汉语成语，同时，笔者并提出了一些意见，以期对对外汉语教学有所帮助。

Агуулгын товч: Аливаа гадаад хэлийг сурахад хамгийн их бэрхшээлтэй зүйлийн нэг бол тухайн улс үндэстний ертөнцийг үзэх үзлээс эхлээд түүх соёл, өв уламжлал, ёс заншил, шашин шүтлэг, ард түмний ахуй амьдралын тусгал болсон хэлц үг билээ. Үүний зэрэгцээ гадаад хэл заах арга зүйн бас нэгэн чухал асуудал болно. Тиймээс бид өгүүлэлдээ хятад хэл заах арга зүйн хүрээнд хятад хэлний үгийн сангийн чухал нэгж болох хэлц үгийн бүтэц, хэрэглээний онцлог, сургалтанд анхаарах зүйлийн талаар авч үзэх нь чухал гэж үзэж байна.

Түлхүүр үг: хятад хэл, хэлц үг, хэлц үгийн онцлог, заах арга

Хятад хэлний хэлц үг нь дараах онцлогтой байна. Үүнд:

Бүтэц нь тогтвортой, ихэвчлэн дөрвөн ханз үсгээс бүтсэн байх боловч нэгдмэл нэг утгатай, соёл ахуйн онцлогийг хадгалсан, яриа болон бичгийн хэлэнд идэвхтэй хэрэглэгддэг тогтвортой хэллэгийн нэг төрөл. Хятад хэлний хэлц үг бүтцийн хувьд ихээхэн ярвигтай боловч ерөнхийд нь нэр хэлц үг (名词性成语) тухайлбал, “一技之长、豪言壮语、天伦之乐、四面八方” гэх мэт; үйл хэлц үг (动词性成语) тухайлбал, “抛头露面、漠不关心、斤斤计较、热泪盈眶” гэх мэт; тэмдэг хэлц үг (形容词性成语) тухайлбал, “豁然开朗、十全十美、千真万确、合情合理” гэж хувааж болно. Хэлц үг хэл зүйн хувьд нэг үгтэй дүйх буюу нэр үг, үйл үг, тэмдэг нэр гэсэн бодит үгийн шинжтэй учраас өгүүлбэрт өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүн, тодотгол, тусагдахуун, байц, нөхвөр зэрэг өгүүлбэрийн аль нэг гишүүний үүрэг гүйцэтгэнэ.

* МУИС-ийн МХСС-ийн Гадаад хэлний тэнхмийн багш, БНХАУ-ын Зүүн Хойд Багшийн Их Сургуулийн докторант

Өгүүлэгдэхүүн гишүүний үүргээр өгүүлбэрт орох нь нэр хэлцийн гол онцлог болж байхад, бүтцийн болон утгын онцлогоос үүдэн үйл хэлц үг өгүүлэгдэхүүн гишүүн болохдоо а. магадлах утга бүхий үйл үг “是” өгүүлэхүүнтэй байх; б. “使、让、令” гэх мэт захирах хүсэх утгатай тусагдахуунтай байх; в. өгүүлэхүүн нь тэмдэг нэр, тэмдэг нэрийн бүтэцтэй байх гэсэн тогтсон нөхцөлийг шаардана. Өөрөөр хэлбэл өгүүлбэр нь: 定语 + 谓词性成语 + 是/使、让、令/形容词或形容词词组 гэсэн бүтэцтэй байна.¹

Үйл үгийн шинжтэй хэлц үг өгүүлэхүүн гишүүн болох нь түүний гол онцлог бөгөөд энэ үед ихэвчлэн тусагдахуун, нөхвөр гишүүн авдаггүй. Энэ онцлогийг анхаараагүйгээс буруу хэрэглэх, цаашлаад инээдэмтэй, эвгүй байдалд орох тохиолдол ч байна. Жишээ нь:

(1) 领班也突然敏感起来, 认为我虎视眈眈他的位置, 对我一反常态, 步步设防。(林坚《别人的城市》)

(2) 一对新郎便在屹立的孙中山先生铜像的注视下拉开了架势。他们虎视眈眈了片刻, 双方同时进击。(池莉《太阳出世》)

“虎视眈眈” хэмээх хэлц үг нь барс адил шуналтай, аймшиггүйгээр цоо ширтэх гэсэн утгатай бөгөөд тусагдахуун, нөхвөр гишүүн авдаггүй. Гэтэл дээрх хоёр өгүүлбэрт “түүний байгаа газрыг цоо ширтэх” буюу тусагдахуун гишүүн, “хэсэг хугацаанд цоо ширтэх” буюу нөхвөр гишүүн нэмж оруулсан нь өгүүлбэр зүйн хувьд алдаатай байна.

Тэмдэг нэрийн шинжтэй, өгүүлэхүүн гишүүн болдог хэлц үг их бий. Хэрэглээний онцлог, тогтсон бүтцийг мөн анхаарах ёстой. Жишээ нь:

(3) 我们想完满地完成任务, 结果却事与愿违。

“事与愿违 – хэрэг явдал урьдчилан тооцсоноос өөр, үр дүн нь муу” гэсэн муушаасан утгатай хэлц үгийг “ажил үүргээ бодож байсныхаа дагуу сайн гүйцэтгэх” гэж эерэг утгаар хэрэглэсэн нь тохирохгүй юм.

(4) 赞口不绝的这家餐厅, 因为离我家较远, 所以没去过。

“赞口不绝 – ам хамхилгүй магтах” гэсэн энэхүү хэлц үг өгүүлбэрт тодотгол гишүүн болохдоо дангаар орох боломжгүй, өөрөөр хэлбэл “大家 бүгдээрээ, 人们 хүмүүс” зэргээр өгүүлбэр заавал өгүүлэгдэхүүн гишүүнтэй байх, мөн бүтцийн туслах үг “的”-г шаардана. Тиймд “大家赞口不绝的这家餐厅, ……。” гэж хэлбэл хэл зүйн хувьд алдаагүй болно.

Үйл үг болон тэмдэг нэрийн шинжтэй хэлц үг тусагдахуун гишүүн болоход өгүүлэхүүн гишүүн буюу үйл үгийн шинж төдийлөн хүчтэй биш, сэтгэлийн хөдөлгөөн заах, хийсвэр утгатай байна. Жишээ нь:

(5) 他在老领导面前显得毕恭毕敬。

“毕恭毕敬” нь “ихэд хичээнгүй, төв цэгц, хүндэтгэлтэй” гэсэн эерүүлсэн утга, “хуурмагаар сайн хүн царайлах” гэсэн муушаасан утгыг илэрхийлэх дундын шинжтэй хэлц үг тул тухайн өгүүлбэрт чухам аль утгаар орж байгааг өгүүлбэрийн хам утга, дээд доод бичвэрээс ойлгож болох юм.

(6) 对此事, 我感到狼狽不堪。

¹ 洪波.对外汉语成语教学探论, 中山大学学报论丛, 299 页.

“狼狽不堪” нь монгол хэлний “гар мухардах”, “гахай явган нохой нүцгэн” гэх мэт хэлц үгтэй утга дүйнэ.

(7) 我把事情忘得一干二净。

“一干二净” буюу “юу ч үлдээлгүй, ор тас” гэсэн утгатай хэлц үг нь ихэвчлэн “мартах, орхих” утгатай үйл үг өгүүлэхүүн болсон өгүүлбэрт ордог байна.

Байц гишүүн болж чадах хэлц үг хэдий цөөн ч бүтцийн туслах үг “地”, утгвар үгийн тусламжтайгаар байц гишүүн болж болно. Жишээ нь:

(8) 人类正在千方百计地防沙治沙。

(9) 端午节那天，人们从四面八方跑到河边来。

Хэл зүйн болон өгүүлбэр зүйн эдгээр онцлогоос гадна хэлц үг бусад үгсийн адил найруулгын эерүүлсэн (褒义) болон муушаасан (贬义) утгыг маш тод томруун илэрхийлдэг. Жишээ нь:

(10) 他做了很多坏事，在这里赫赫有名。

“赫赫有名” нь нэр цуутай хэмээх эерүүлсэн утгатай тул муу үйлийг хэлэхгүй юм.

(11) 经过努力，他的汉语水平有了很大的提高，他这是自食其果。

“自食其果” нь “өөдөө шидсэн чулуу өөрийн толгой дээр” гэсэн муушаал утгатай тул “хичээн суралцсанаар түүний хятад хэлний түвшин ихэд дээшилсэн” гэх тухайд хэрхэвч хэрэглэж болохгүй. Хэлц үгийг бичгийн болон ярианы хэлэнд зөв хэрэглэхэд тухайн найруулгыг уран яруу, амьдлаг, баялаг болгодог онцлогтой ч сурагчид хэлцийн утга, хэрэглээ, онцлог, найруулгын өнгө аясыг сайтар эзэмшээгүйгээс буруу ойлголцох явдал байнга гардаг. Эдгээр онцлогоос үүдэн хятад хэлний хэлц үг заах аргын тулгамдсан асуудлыг авч үзье.

Өдгөө хятад хэлний танхимын сургалтын дунд буюу дээд түвшний /хятад хэлний сургалттай бага, дунд сургуулийг хамруулаагүй болно/ сурах бичиг, гарын авлагад “хэлц үг – галиг – шууд орчуулга” хэлбэрээр оруулсан байдаг ч монгол хэлээр хэвлэгдсэн нь ховор, ихэвчлэн англи, орос хэлээр тайлбарласан ном сурах бичгийг дам орчуулах байдлаар хэрэглэж байгаа тул хэлц үгийн утга, хэрэглээний онцлогийг монгол хүн сурч эзэмших тал дээр төдийлөн хангалттай биш байгаа нь ажиглагдаж байна. Хоёр хэлний толь бичигт хэлц үгийн онцлог, хэрэглээний шинжийг тайлбар зүүлт хийж, жишээ гарган тайлбарласан нь нэн ховор. Үүнээс гадна, хэлц үгийн хэл зүйн хэв шинжийг сайтар ялгаж таниагүй байх, тогтсон бүтцийг орхигдуулах, өгүүлбэр дэх өнгө аясыг андуу ташаа хэрэглэх, дэс дарааг хольж хутгах, шилжсэн болон зүйрлэсэн утгыг эс мэдэх, цаашлаад түүх соёлын талаас хэлц үгийн гарал үүслийг мэдэхгүйгээс болж тогтсон ханзыг солих, утгыг алдагдуулах зэрэг олон асуудал бий. Хэлц үг заах аргад доорх хэдэн зүйлийг анхаарууштай гэж үзэж байна. Үүнд:

Заах аргад хэлц үгийн бүтцийн онцлогийг чухалчлах нь: Судлаач Ван Тао (王涛) эрхлэн Шанхайн толь бичиг хэвлэлийн газраас (上海辞书出版社) 2007 онд хэвлэн гаргасан «中国成语大辞典» толь бичигт 18000 орчим хэлц үг багтааснаас 96 орчим хувь нь дөрвөн үе буюу дөрвөн ханз үсгээс бүтсэн хэлц үг байгаа нь хятад хэлний хэлц үг ерөнхийдөө дөрвөн ханз үсгийн бүтэцтэй (四字格) болохыг харуулж байна. Түүнчлэн хятад хэлний хэлц үгийн бүтцэд орсон үгсийн байрлал, тогтсон дарааллыг өөрчлөх,

дурын өөр үгээр солих, бүтцэд шинээр үг нэмэх буюу хасах боломжгүй, тогтвортой шинжтэй. Жишээ нь:

眼高手低 гэхийг 手低眼高 гэж байрлалыг солих, 笨鸟先飞 гэхийг 笨猪先跑 гэж өөр үгээр солих, 豁然开朗 гэхийг 豁然又开朗 гэж үг нэмэх, 三言两语 гэхийг 三两语 гэж үг хасах зэргээр бүтцийг өөрчилж болдоггүй.

Заах аргад хэлц үгийн утгыг чухалчлах нь: Хятад хэлний хэлц үгийн адилтгал утга (隐喻意义), шилжсэн утга (引申义), зүйрлэсэн утга (比喻义) болон тайлбар нэмэлт утгыг (附加意义) сурагчдад сайтар эзэмшүүлэх нь зайлшгүй чухал юм. Ижил дуудлагатай үгс, ойролцоо зурлагатай үсэг, ханзны олон утгыг бас харгалзууштай.

Жишээ нь: “大腹便便” (цүл цал хийсэн бүдүүн гэдэстэй) хэмээх хэлц үгийн “便便”-г “bian bian” биш “piǎn piǎn” гэж, “朝气蓬勃” (сүр жавхлантай омог бардам) гэх хэлц үгийн “朝”-г “cháo” биш “zhāo” гэж, “臧否人物” (хүнийг муу сайнаар хэлэх) хэлц үгийн “否”-г “fǒu” биш “pǐ” гэж уншсанаар хэлц үгийн утгыг зөв ойлгож, зөв хэрэглэх учиртай.

Сурагч хэлц үгийн бүтэц дэх аль нэг ханзны утгыг мэддэгээсээ бүтэн хэлцийг тэр үгийн утгаар андуу ойлгох нь бий. Жишээ нь:

* 过年了, 李民一家人过得一团和气。 “Ямар нэг зааг зарчимгүй тайвуу байдал” гэсэн утгыг дээрх жишээнд “гэр бүлийн халуун дулаан уур амьсгал” (气氛和谐) гэж ташаарчээ.

Мөн ханзны олон утгыг бүрэн мэддэггүйгээс буруу хэрэглээ үүснэ. Жишээ нь:

* 李丹、王力时刻觉得人满为患。 “患” ханзны “өвчин, өвчтөн” хэмээх утгаас гадна “яршиг төвөг” гэсэн утгыг мэдэхгүйгээр “хүн олноор цугласнаас төвөг чирэгдэл болох” гэсэн хэлц үгийн утгыг эс ойлгоход хүрнэ. Үүнтэй нэгэн адилаар “生气勃勃” гэсэн хэлц үг “баярлах, урам зоригтой байх” гэсэн утгатай. Гэтэл сурагч эхний хоёр ханз үсэг болох “生气” гэдэг үгийн зөвхөн “уурлах” гэсэн утгаар бүтэн хэлц үгийн утгыг ойлгосноор эндүүрдэг.

Заах аргад хэлц үгийн хэл зүй, өгүүлбэрзүйн онцлогийг чухалчлах тухай дээр тодорхой дурдсан билээ.

Заах аргад хэлц үгийн гарал үүслийн онцлогийг чухалчлах нь: Хятад хэлний хэлц үгийг гарал үүслийн орноор нь хэд хэд хуваан үзэж болно. Үүнд: 古代神话寓言 буюу эртний үлгэр домгын, 历史故事 буюу түүхэн үйл явдлын, 古代文献记载 буюу эртний сурвалж бичиг, тэмдэглэлийн, 口头俗语 буюу ярианы хэл, сургааль үгийн, 外来语 буюу харь хэлний ормол үгийн үүдэлтэй гэх мэт. Хэлц үгийн нийлэмжид орсон үсэг бүрийн утгаас утгыг бүрэн ойлгож болох хэлц үгс байхад түүхэн үйл явдал, үлгэр домгийг ойлгож байж утга нь сая мэдэгдэх хэлц үг олон бий. Тухайлбал, “自相矛盾” нь Хавар намрын байлдаант улсын үеийн ёгт үлгэрээс, “守株待兔” нь Сун улсын нэгэн тариачны домгоос, “愚公移山” нь Аливаа ажлыг шантралгүй тууштай хийвэл хүссэн үр дүндээ хүрч болохыг өгүүлсэн Байлдаант улсын үеийн үлгэрээс, “完璧归赵” нь Баруун Хань улсын түүхч Сы Ма цань-ий «Түүхэн тэмдэглэл»-ээс үүссэн байдаг. Иймд хэлцийн гарал үүслийн судалгааг хятад хэлний хэлц судлалын чухал судлагдахуун болгодог байна. Хэлц үгийг түүний гарал үүсэлтэй холбон тайлбарлах нь танхимын сургалтанд төдийгүй суралцагч хятадын түүх, хэл-соёл, хэл-орон судлалын талаар цогц ойлголттой

болж, улам бататган баяжуулах, сурах идэвх сонирхол, сэдлийг төрүүлэх ихээхэн ач холбогдолтой.

Дүгнэлт:

Хятад хэлний хэлц үгийн онцлогийг монгол хүний сэтгэхүйн онцлогтой уялдуулан, мөн хэлц үгийн гарал үүслийг түүхэн үйл явдалтай нь холбон тайлбарлахын зэрэгцээ хэлц үгийн үндсэн утга, шилжсэн утга, зүйрлэсэн утгыг үндэстний соёл сэтгэлгээний өвөрмөц онцлогтой хамтатган ойлгуулах нь хамгийн чухал юм. Хятад хэлний хэлц үг хятад орны өнө удаан жилийн түүх, хятад үндэстний амьдрал ахуй, эдийн засаг, соёл, зан заншил, сэтгэхүйн аргыг илт тусгасан байдаг. Тиймээс багш хэлц үг бүрийг тайлбарлахдаа дээрх онцлогуудад тулгуурлан хэл зүй, үг зүй, өгүүлбэр зүйн талаас, хэрэглээ талаас утгачлан, жишээ үг өгүүлбэрээр бататган монгол хэлнээ дүйх хэлц үгээр оноон сурагчдад эзэмшүүлэх нь чухал билээ.

НОМЗҮЙ

1. “Монгол Улсын шинжлэх ухаан” (2009). УБ, ШУА, ХЗХ, боть 12.
2. Г.Сүлд-Эрдэнэ, Б.Уянга нар (2011). “Монгол хэлний өвөрмөц хэлцийн толь”, УБ, Мон судар хэвлэлийн газар.
3. 阿如那《试论蒙古族学生的汉语成语教学》, 内蒙古民族大学学报, 第 14 卷第 6 期, 2008.
4. 洪波《对外汉语成语教学探论》, 中山大学学报论丛, 第 23 卷第 2 期, 2003.
5. 周建民《成语在功能和意义上的活用》, 武汉教育学院学报, 第 20 卷第 5 期, 2001.

SUMMARY

In this article, the author has explained the peculiarities of Chinese phrases; its literal meaning, figurative meaning and metaphorical meaning which strongly connect to its national mentality. Chinese phrases reflect the history of China, its peoples' lifestyle, culture, custom, economy and thinking. Teaching Chinese to Mongolian students, it is necessary to explain phrases from the point of etymology, lexicology, morphology and syntax base on the mentality of Mongolians and translating phrasal equivalents in Mongolian.